

## ОУИТБС-ЫН БАРУУН БҮСИЙН III ЧУУЛГАНААС ГАРГАХ ЗӨВЛӨМЖ

2021.10.27

Улаанбаатар хот

“Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Баруун бүсийн Ш чуулган” 2021 оны 10 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд цахим /онлайн/-аар зохион байгуулагдаж, УУХҮЯ, СЯ, АМГТГ, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан Увс, Ховд аймгийн ЗДТГ зэрэг төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын, МУУҮА, Нүүрс Ассоциаци, Рио Тинто ХХК, Оюу толгой ХХК, Баян айраг эксплорейшн ХХК, Шувуун хар уул, Моннис зэрэг хувийн хэвшлийн, Төлсөн Авснаа Нийтэл ТББ-ын эвслийн төлөөлөл, Олон улсын санхүүгийн корпораци зэрэг олон улсын донор байгууллагуудын, болон ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, алба, дурдсан аймгуудын Дэд зөвлөлийн төлөөллүүд тус тус оролцлоо.

Чуулганд оролцогсод ОУИТБС-ыг орон нутагт идэвхжүүлэх, түүний Дэд зөвлөлийг чадавхжуулах чиглэлээр анхаарч, хамтран ажиллах, гарсан санал, санаачилгуудыг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлж, дараах зөвлөмжүүдийг гаргахаар тогтов. Үүнд:

### **1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд:**

- 1.1. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах ажлыг яаравчлах; төсөлд Дэд зөвлөлийн санхүүжилтийн асуудлыг суулгах;
- 1.2. УУХҮ-ийн сайд, Аймгуудын ЗД-тай байгуулсан хамтран ажиллах 2021 оны гэрээг дүгнэхдээ нийт онооны 5 хүртэл хувиар үнэлэх, 2021 оны гэрээнд Дэд зөвлөлийн үйл ажиллагааг удирдах, чиглүүлэх гэрээнд үнэмлэхүй жин дарах хэмжээнд тусгах;
- 1.3. Уул уурхайн ачаалал ихтэй орон нутагт салбар нэгж бий болгох төсөв орон тоог 2022 оны төсөв тусгаж батлуулах

### **2. Сангийн Яаманд:**

- 2.1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх, ЗГ-ын 2017 оны 263-р тогтоолд заасан СЯ-ны хүлээх үүргийн хэрэгжилтийг хангах;

### **3. Ашигт малтмал, газрын тосны газарт:**

- 4.1. Тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн саналд үнэдслэн тусгай зөвшөөрөл олгодог болох;
- 4.2. Орон нутагт олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн системтэй байх;
- 4.3. Бичил уурхайн эрх зүйн болон зохион байгуулалтыг тодорхой болгож тэдэнд ил тод нээлттэй байдлын стандартыг мөрдүүлэх, хариуцлагыг тодорхой болгох
- 4.4. АМГТГ-аас орон нутгийн захиргаа, Дэд зөвлөлд шинээр гарсан эрх зүйн зохицуулалтын талаар шуурхай мэдээлэл, мэдлэг өгдөг байх, Мэдээллийн зөрүүтэй байдал үүсэхээс сэргийлэх,

### **4. Баруун бүсийн аймгуудын Засаг дарга нарт:**

- 5.1. Дэд зөвлөлийн гишүүдээ сургах талаар хамтран ажиллах, сургалтыг тогтмолжуулах;
- 5.2. Аймаг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг аймаг сумдын ОУИТБС-ын Дэд зөвлөлд оруулах, мэдээллийн хүртээмжээ нэмэгдүүлэх;
- 5.3. Эрдэс баялгийн салбарт чиг үүрэг нь холбогдох төрийн байгууллагуудын ажлын болон нээлттэй мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, нэгтгэх;
- 5.4. Орон нутагт төлсөн татварын зарцуулалтыг ил тод болгох;

- 5.5. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг тодорхойлж, гаргах бүтээгдэхүүнийг ЗДО даргын үр дүнгийн гэрээнд тусгах, дэд зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжуудыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж тайланг нээлттэй болгох;
- 5.6. Дэд зөвлөлийн төлөвлөгөөг ОУИТБС-ын ОТОАХ-эс батласан загвар зөвлөмжийн дагуу боловсруулах, үйл ажиллагааг тогтмол танилцуулж, сурталчилж байх;

## **6. Нутгийн өөрөө удирдах байгууллагад:**

- 6.1. Аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурал тухайн шатныхаа дэд зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, төсвийг баталдаг байх
- 6.2. ИТХ нь төлөөлөгчдийн болон холбогдох хороодод ОУИТБС түүний стандарт, Дэд зөвлөлийн чиг үүргийн талаар тогтмол мэдлэг мэдээллээр хангах, хамтарсан хяналт мониторинг хэрэгжүүлж, олон талт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж хэвших ;

## **7. Компани, бичил үүрхай эрхлэгчдэд:**

- 7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь жил бүрийн БОМТ, ОХШХ-ийн төлөвлөгөө, тайланг олон нийтэд тайлагнах үүргээ, тухайн шатны Дэд зөвлөлийн жилийн ажлыг төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж хэвших;
- 7.2. Тухайн орон нутгийн иргэд, олон нийтэд АМТХ-ын 48.10 дагуу мэдээллийг нээлттэй болгох үүргээ хэрэгжүүлэхдээ ИТХ, дэд зөвлөлийн дэмжлэгтэйгээр хамтран зохион байгуулж хэвших.
- 7.3. АМТХ-ын 42-р зүйлийн дагуу Хамтран ажиллах гэрээ батлахын өмнө нутгийн захиргаа Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийгээгүй бол гэрээг үзэглэхгүй байхыг анхаарах, сонсох ажиллагаа хийхийг шаардах.
- 7.4. Хамтран ажиллах гэрээний хүрээнд нутгийн захиргаанд хандив дэмжлэг үзүүлэхдээ түүний тодорхой хувийг олон нийтэд нээлттэй мэдээлэх ажлын зардал гаргах заалтыг заавал гэрээнд тусгаж түүнд хяналт тавьж хэвших
- 7.5. Нутгийн иргэдэд ажлын байрны мэдээллийг компани өөрөө түргэн шуурхай мэдээлж байх;

## **8. ТАН /Төлсөн Авснаа Нийтэл/ эвсэлд:**

- 8.1. Аймаг, сумын дэд зөвлөлд оролцож буй Иргэний нийгмийн байгууллагуудыг эрдэс баялгийн ил тод байдлыг хангаж ажилахад нь шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгох, сайн туршлага, сургамж хуваалцах бүсийн арга хэмжээ тогтмол зохион байгуулах;
- 8.2. Баруун бүсийн аймаг, сумын дэд зөвлөлийн үйл ажиллагаанд талуудын оролцооны идэвхи, ажлын гүйцэтгэлд хагас жил тутамд мониторинг хийх, зөвлөн туслах;
- 8.3. Аймаг, сумын дэд зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах арга зүй боловсруулж ОТОАХ-ээр батлуулан мөрдүүлэх; 2021 оны 12 сард

## **9. ОУИТБС-ын Ажлын албанд:**

- 7.1 ОУИТБС-ын үндэсний вэб сайтад цэс үүсгэж irgen-data гм мэдээллийг хялбаршуулсан, хүртээмжийг сайжруулсан хөгжүүлэлт хийх ;
- 7.2 “Дэд зөвлөл-2025” хөтөлбөр боловсруулж ҮЗ-өөр батлуулах. /Дэд зөвлөлүүдэд түргэн шуурхай зөвлөн туслах зохион байгуулалт хийх. /дэд зөвлөлийн талуудад дагнасан байдлаар эсвэл сумд аймгийн дэд зөвлөлийн шуурхай зөвлөлдөх уян хатан механизм бий болгох; Суманд хамааралтай мэдээллийг сумын Дэд зөвлөл өөрсдөө нээлттэй болгох арга зам; Дэд зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх маягт

боловсруулж, хэлэлцүүлэн батлах; Аймаг, сумын дэд зөвлөлийн чиг үүргийн ялгааг заагийг тодорхой болгож өгөх санал гаргах; Дэд зөвлөлүүдийн зайлшгүй хийх ажлыг тодорхойлж өгөх, зоримог шинэлэг ажлуудыг хийх урамшуулах талаар тооцох; Дэд зөвлөлийг мэдээлэл хүргэх хэрэгсэл болгох талаар санаачлагатай ажиллах зэрэг асуудал багтаасан байна;

7.3 ҮЗ-ийн хурлын материалууд, жилийн тайланг нэн даруй хэвлэн хүргүүлдэг болох, орон нутгийн цахим оролцооны хүчин чадлын ялгаатай хөгжлийг анхаарах;

8. Бүх оролцогчид, зохион байгуулагч нарт:

8.1 Төв орон нутаг гэлтгүй бүгд цахим орчинд ажиллаж сурах, бэлтгэлтэй оролцох;

8.2 ОУИТБС-ын хүрээнд гарч байгаа мэдээллийг ашиглах хэрэгтэй байгааг анхаарах;

8.3 Мэдээллийг илүү өргөн хүрээнд бий болгох, хэлэлцүүлдэг байх;

8.4 Хайгуулын мэдээллийг уул уурхайтай аль болох холбохгүй, хайгуулын ажлыг аль болох урагшлуулах чиглэлээр түлхүү анхаарч хэлэлцдэг байх, хайгуулын мэдээллийг иргэдэд ойлгомжтой болгох, мэдээллийг зөв ойлгуулахад компаниуд түлхүү анхаарч ажиллах;

8.5 Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр аймаг сумдад ямар хэмжээнд байгааг ил тод болгох, хайгуулын ажлын онцлогийг малчин иргэдэд ойлгуулах;

**ОУИТБС-ын Баруун бүсийн Ш чуулганы оролцогсод**